



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/306

Булган сум

### Ажлын хэсэг байгуулж, хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан “аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.1.3.1, 1.6.1.1, 1.6.1.6, 1.6.3.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөөгийн хүн амд чиглэсэн төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн суурь үйлчилгээг нэг дороос хурдан шуурхай, чанартай хүргэх зорилгоор “Хүрч үйлчилье” нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. “Хүрч үйлчилье” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: М.Батчимэг (аймгийн Засаг даргын тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: Н.Батжаргал (Хөдөлмөр халамжийн үйлчилгээний  
газрын дарга)

Ц.Энх-Амгалан (Нийгмийн даатгалын хэлтсийн дарга)

Б.Ариунболд (Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн  
дарга)

Ж.Гүндэгмаа (Эрүүл мэндийн газрын мэдээлэл сургалт  
сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн)

О.Эрдэнэцэцэг (Эрүүл мэндийн газрын халдварт бус  
өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн)

Ч.Одсүрэн (Нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн эмч)

Б.Мөнхдэмбэрэл (Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын  
тасгийн эмч)

Д.Буянхишиг (Нэгдсэн эмнэлгийн Сүрьеэгийн тасгийн  
эмч)


М.Ариунаа (Нэгдсэн эмнэлгийн шүдний эмч)

Э.Одмаа (Нэгдсэн эмнэлгийн Дэмжих төвийн эмч)  
Н.Ундрах (Нэгдсэн эмнэлгийн СДЗШӨК-ийн эмч)  
Б.Батболд (Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын  
хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч)  
Г.Нарантуяа (Биеийн тамир спортын газрын арга зүйч)  
Д.Нямсүрэн (Улаан загалмайн хорооны арга зүйч)  
Я.Нямсүрэн (Боловсрол шинжлэх ухааны газрын Биеийн  
тамирын боловсрол хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: М.Солонго (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

3.Арга хэмжээг чанартай, хурдан шуурхай зохион байгуулж, мэргэжил арга зүй, удирдлагаар ханган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга, Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасгай.

4.“Хүрч үйлчилье” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталж, 3,146,500 (гурван сая нэг зуун дөчин зургаан мянга таван зуун) төгрөгийг “Эрүүл мэнд” хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны  
04 дүгээр сарын 29-ны өдрийн А/З06 дугаар  
захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ “ХҮРЧ ҮЙЛЧИЛБЭ” НЭГДСЭН  
АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

Д/д	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт
1	2	3	4	5	6
1.	Шатахууны зардал (4 машин 1360 км)	Литр	245	2520	600,250
2	Шатахууны зардал (2 машин 680 км)	Литр	125	4370	546250
3.	Хүнсний багц (гурил, будаа, тос)	Өрх	40	50000	2,000,000
	Дүн				3146500